

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ
(2024 оны зорилтод түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр)**

2024 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

№	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн			Хэрэгжилтийн явц	Хувь
								Зорилтот түвшин, үр дүн	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
БҮЛЭГ: ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ												
Зорилго 4. Инновацад тулгуурласан, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны бөөгнөрлийг дэмжиж, бүтээлч, бие даасан, тогтвортой эдийн засагтай хот болох суурийг бүрдүүлнэ.												
Эдийн засгийн тэргүүлэх чиглэл												
Зорилт 4.3.Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ.												
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.3.1. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна.	Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ	2021-2025	НАЖГ	-	-	-	1	-	-	Нийслэлийн аялал жуулчлалыг 2022-2025 онд хөгжүүлэх 4 жилийн арга хэмжээний төслийг Үндэсний хөгжлийн газар, аялал жуулчлалын салбарын мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Улаанбаатар хотын аялал жуулчлалыг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар “Найрсаг Улаанбаатар-2” нийслэлийн Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг батлуулсан. “Найрсаг Улаанбаатар-2” нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх 7 зорилтын 77 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 2022 онд 70 хувь, 2023 онд хувь, 2024 оны зорилтод түвшний үзүүлэлтээр 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	100
2		Хүлээн авах гадаад жуулчдын тоо	2021-2025	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	0.5	0.8	1,153.8	1,129.8	Монгол Улс 2021 онд 33,100 жуулчин, 2022 онд 286,282 жуулчин, 2023 онд 651,061 жуулчин хүлээн авсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж 2024 онд 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлэн	90

										<p>Монгол Улс гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд “Go Mongolia” түлхүүр үгийг, Улаанбаатар хот “Visit Ulaanbaatar” логог ашиглаж үйл ажиллагаагаа сурталчилсан.</p> <p>“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 15 эвент арга хэмжээг зохион байгуулж нийт гадаад, дотоодын 352,050 хүн үзэж сонирхон эдийн засагт 27,197.9 (хорин долоон тэрбум нэг зуун ерэн долоон сая есөн зуун мянга) төгрөгийг эргэлтэд оруулсан. Мөн Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор олон улсын 7 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож, 3 арга хэмжээг хамтран зохион байгууллаа.</p> <p>Монгол Улс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийт 766,243 жуулчин хүлээн авсан нь өмнөх онтой харьцуулахад 115,182 жуулчнаар буюу 23.1 хувийн өсөлттэй, зорин ирж буй жуулчдыг улсаар нь авч үзвэл нийт жуулчдын 203,788 буюу 26.5%-ийг ОХУ, 202,000 буюу 26.3%-ийг БНХАУ, 190,182 буюу 24.8%-ийг БНСУ, 25,079 буюу 3.2%-ийг Япон, 23,457 буюу 3.0%-ийг БНКазахстан Улсын жуулчид ирсэн үзүүлэлттэй байна.</p>	
3	Шинээр нэвтрүүлсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ	2021-2025	НАЖГ	Нийслэлийн төсөв	-	13	21	1,024.0	994.5	<p>Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд “Сонгинохайрхан уулын явган аяллын замын тохижилт, “Хийморь” олон улсын морьт харвааны наадам, “Уухай” шагайн харвааны наадам зэрэг 3 арга хэмжээ, 2022 онд “Их тэнгэрийн амны хадны зураг” орчны тохижилт, “Жуулчин төгөл”, “Францын соёл, аялал жуулчлалын өдрүүд зэрэг 3 арга хэмжээ, 2023 онд “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын тохижилт, “Visit Ulaanbaatar” гар утасны аппликейшн, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “UB bike tour” олон улсын</p>	90

